

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР, ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ *
(2018 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1.	Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана).	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Төсөл-2 Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд 2011 оны 12 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан “Хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр”-ээр “Баруун бүсийн авто замын коридор хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхээр тохиролцсон ба талуудын хооронд тус хөтөлбөрийн 2 дугаар үе шатны төсөл буюу “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх МОН-3129 зээлийн гэрээг 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан.			
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Азийн Хөгжлийн Банкны МОН-3129 зээл			
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: Зам, тээврийн хөгжлийн яам			
		Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сангийн яам, Азийн хөгжлийн банк			
	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1: Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх, Азийн авто замын АН-4 сүлжээний ая тухтай зорчих нөхцлийг бүрдүүлэх. Зорилт 2: Барилга угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн шаардлагын дагуу чанартай хийж гүйцэтгэх.			
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	125 сая ам.доллар		
		Үүнд:	Төсөв /нийт/	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1-1	22.6 сая ам.доллар	19.12 сая ам.доллар	84.52%
		Багц 1-2	27.4 сая ам.доллар	24.70 сая ам.доллар	90.00%
		Багц 1-3	36.5 сая ам.доллар	20.35 сая ам.доллар	55.72%
		Багц 1-4	-	-	0
	Зөвлөх үйлчилгээ	4.99 сая ам.доллар	3.39 сая ам.доллар	67.94%	
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ.			
	1-р зорилтын хүрээнд:	1-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: Азийн авто замын сүлжээний АН-4 авто зам нь Монгол Улсын нутаг дэвсгэрээр 741.3 км дайран өнгөрдөг бөгөөд тус авто замын сүлжээний 74% буюу 511 км авто зам хатуу хучилттай болсон бөгөөд үлдэж байгаа нийт 189.7 км авто замыг энэхүү энэхүү төслийн хүрээнд 4 багц хэсгээр барьж байгуулахаар төлөвлөсөн. Төслийн хүрээн дэх авто замыг ашиглалтад оруулснаар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх Азийн авто замын сүлжээний АН-4 чиглэлийн авто зам бүрэн хатуу хучилттай болж олон улсын дамжин өнгөрөх тээвэрлэлтийн ая тухтай, аюул осолгүй, найдвартай зорчих нөхцөл бүрдэх юм. Төслийн хүрээнд хэрэгжих Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлаас 106.9 км авто замын ажил дуусаж ашиглалтад			

		<p>орсон. 60 км авто зам 57.3 хувийн хэрэгжилттэй, 2019 онд ашиглалтад орно. 25.7 км замыг 2019 онд эхлүүлэхээр төлөвлөсөн. Нийт төслийн барилгын ажлын гүйцэтгэл 80%-тай байна.</p>
	<p>2-р зорилтын хүрээнд:</p>	<p>2-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл: Зам барилгын ажлын Багц 1-1 хэсэг буюу Хашаатын даваа-Шургын гүүр чиглэлийн 50 км, Багц 1-2 буюу Шургын гүүр-Ховд чиглэлийн 56.6 км нийт 106.6 км авто замын ажил техникийн шаардлагын дагуу хэрэгжиж, 2018 оны 12 сард улсын ашиглалтад орсон. Багц 1-3 хэсэг буюу Хашаатын даваа-Толбо чиглэлийн 60 км авто замын барилгын ажил 57.3 %-ийн хэрэгжилттэй, 2019 оны 9 дүгээр сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Зам барилгын ажлыг стандарт, норм дүрэм, техникийн шаардлагын дагуу гүйцэтгүүлэх хүрээнд өдөр тутмын техник, технологийн хяналтыг БНЭУ-ын “Ай Си Ти Сайн” компани хэрэгжүүлж байна.</p>
<p>7.</p>	<p>Дүгнэлт (ололт, анхаарах асуудлууд) дугагдал,</p>	<p>Төслийн хүрээнд хэрэгжиж буй 4 багц зам барилгын ажлын Багц1-1 болон Багц1-2-ын нийт 106,6 км авто замын барилгын ажил гэрээний дагуу 2018 онд ашиглалт орсон. Багц1-3-ийн барилгын ажил 57.3%-ийн хэрэгжилттэй байна. Зам барилгын ажлын гэрээний хэрэгжилтийн Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2018 оны 8 дугаар сард дүгнэсэн. Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн гэрээг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгахаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан. “Гадаадаас авч ажиллуулах ажиллах хүчний зөвшөөрөл” ХНХЯамнаас шалтгаалан хэт удааширч шийдвэрлэгдэж байсан нь багц1-3 хэсгийн зам барилгын ажлын график төлөвлөгөөнд сөргөөр нөлөөлсөн байна. Цаашид гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд “Гадаадаас авч ажиллуулах ажиллах хүчний зөвшөөрөл”-ийг цаг алдалгүй гаргаж, зам барилгын ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжих нөхцлийг бүрдүүлж байх шаардлагатай байна. Багц 1-4 хэсгийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд 2015 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр тендерт оролцогчоос Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргасан ба шүүхийн шийдвэр гартал барилгын ажлыг түр түдгэлзүүлсэн. Шүүхийн шийдвэр 2016 оны 10 дугаар сарын 26-ны өдөр гарсан. Шүүхийн шийдвэрээр Барилгын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан Чайна Хуаши Энтерпрайзиз Лимитед Компанитай байгуулсан гэрээг цуцлаж, Алтайн зам ХК-тай гэрээ байгуулахыг ЗТХЯ-нд даалгасан. Шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд ЗТХЯ нь Чайна Хуаши Энтерпрайзиз Лимитед Компанитай байгуулсан гэрээг 2017 оны 06 сарын 30-ны өдөр цуцалсан. “Алтайн зам” ХК-тай 2018 оны 05 дугаар сарын 11-ний өдөр 105 дугаар бүхий гэрээг байгуулж, холбогдох журмын дагуу АХБ-нд хүргүүлсэн. Гэвч АХБ-аас тус гэрээг АХБ-ны журамд нийцэхгүй үндэслэлээр санхүүжүүлэх боломжгүй гэсэн мэдэгдлийг 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдөр ирүүлсэн.</p>

		<p>АХБ-аас ирүүлсэн мэдэгдлийг үндэслэн “Алтайн зам” ХК-нд 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 03/2373 албан тоотор зам барилгын ажлын гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлсэн.</p> <p>АХБ-аас Шүүхийн шийдвэр хүчингүй болсон тохиолдолд тус багц хэсэгт санхүүжилт хийх боломжтойг мэдэгдсэн.</p> <p>Ийнхүү тендерт оролцогч компанийн гомдол, шүүхийн шийдвэрээс шалтгаалж баруун бүстйн босоо тэнхлэгийн авто замын сүлжээнд 25.8 км авто зам баригдахгүй үлдэж болзошгүй байгаа ба АХБ-ны хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг ашиглах хүрээнд шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулах шаардлагатай байна.</p>			
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төсөл хэрэгжүүлэгч талуудын хоорондын хамтын ажиллагаа сайн байна.			
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж 95 %	Зорилтын тоо 2	Зорилт 1 90%	Зорилт 2 100%
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ ... %			